



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гаалийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/105/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Ухаанбилэг

Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн



Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	3
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	3
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	3
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	3
3. Аудитын тайлан.....	4
3.1. Ерөнхий зүйл.....	4
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	4
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	4
3.4. Материаллаг байдал.....	5
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	5
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	7
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	8
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
3.9. Аудитын илрүүлэлт.....	9
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	9
Аудитын зөвлөмж.....	10
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	10
4. Менежментийн захидал.....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	12



1.Хараат бус аудиторын дүгнэлт

Гаалийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.Хараат бус аудиторын дүгнэлт




**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 188

танай _____ -ны № _____ -т



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА
ДОРНОД АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН
Ж/ОА0056.9030891
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГЭРЭЛТ-ОД
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гаалийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гаалийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Гаалийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Гаалийн газар 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 76.5 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэл, буруу мэдээлэл шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.



ᠳᠠᠷᠭ᠋ᠢ ᠪᠡᠭᠡᠳᠡ
ᠲᠡᠷᠭᠡᠭᠦᠯᠡᠬᠡ ᠠᠳᠢᠲᠣᠷ
ᠨᠠᠭᠤᠯᠠᠭ
ᠨᠠᠭᠤᠯᠠᠭ

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	98343024.04	76783186.74
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
33	АВЛАГА	851500.00	1865661.43
335	Бусад авлага	851500.00	1865661.43
3351	Байгууллагаас авах авлага	851500.00	1865661.43
35	БАРАА МАТЕРИАЛ	97491524.04	74917525.31
351	Түүхий эд материал	21445487.87	4265728.88
35110	Тусгай зориулалттай материал	21445487.87	4265728.88
35300	Бэлэн бүтээгдэхүүн	5724775.00	5647295.00
354	Хангамжийн материал	51791261.17	47454501.43
35420	Аж ахуйн материал	28922506.52	22003708.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	3027730.00
35470	Бусад хангамжийн материал	22868754.65	22423063.43
35600	Мал амьтад	18530000.00	17550000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9224455724.92	10696790316.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9224455724.92	10696790316.53
392	Биет хөрөнгө	9129130724.92	10512474656.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	9833853736.85	10579409798.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1302560860.64	-1526186075.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	490325205.73	367969485.73
39204	Хуримтлагдсан элэгдэл	-421202983.31	-305943096.88
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2002252637.27	2822438729.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1508167160.58	-1478457910.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	109248070.05	130207230.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-74617920.45	-76963505.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	2221100.00	2221100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2221100.00	-2221100.00
393	Биет бус хөрөнгө	95325000.00	184315660.00
39301	Програм хангамж	950000.00	950000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-950000.00	-950000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	95325000.00	184315660.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9322798748.96	10773573503.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	464670.69	1034169.43
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	464670.69	1034169.43
413	Өглөг	464670.69	1034169.43
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5498.00	0.00
4136	Бусад өглөг	459172.69	1034169.43
41361	Байгууллагад төлөх өглөг	192545.00	0.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	248119.69	1015661.43
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	18508.00	18508.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9322334078.27	10772539333.84
51	Засгийн газрын хувь оролцоо	9322334078.27	10772539333.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3742699468.58	3742699468.58
51101	Өмч: - төрийн	3742699468.58	3742699468.58
512	Хуримтлагдсан үр дүн	4953905198.19	6404110453.76
51210	Өмнөх үеийн үр дүн	4953905198.19	4953905198.19
51220	Тайланг үеийн үр дүн	0.00	1450205255.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	625729411.50	625729411.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9322798748.96	10773573503.27



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	1709975124.00	3444687492.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	484138024.00	1841994292.00
120	Нийтлэг татварын бус орлого	484138024.00	1841994292.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	476648524.00	1825274292.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	476646224.00	1825274292.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2300.00	
120009	Бусад орлого	7489500.00	16720000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1225837100.00	1602693200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1225837100.00	1602693200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1225837100.00	1602693200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1619184439.42	1994461806.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1619184439.42	1994461806.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1611597101.42	1881972374.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	879996206.68	1050927852.88
210101	Үндсэн цалин	437946579.09	517245048.89
210102	Нэмэгдэл	417784627.59	504352803.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24265000.00	29330000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111415161.38	131916916.43
210201	Тэтгэврийн даатгал	10752931.38	12876882.71
210202	Тэтгэмжийн даатгал	28896593.98	22754821.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	20866019.60	630721.02
210204	Ажил үйлчллийн даатгал	26542288.38	32265545.66
210205	Эрүүл мэндийн даатгал	24357328.04	63388945.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77381722.00	66457204.00
210301	Гэрэл, цахилгаан	34921227.00	30246106.00
210302	Түлш, халаалт	39461900.00	34828868.00
210303	Цэвэр, бохир ус	2998595.00	1382230.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37240162.00	99228063.74
210401	Бичиг хэрэг	2744747.00	3434300.00
210402	Тээвэр, шатахуун	29946000.00	54448130.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1024915.00	1008552.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	724500.00	648100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2800000.00	10881000.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	28807981.74
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40479000.00	32831407.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1700000.00	1504997.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1000000.00	5894540.00
210604	Урсгал засвар	37779000.00	25431870.00
2107	Томилолт, зочны зардал	2075500.00	1763400.00
210702	Дотоод албан томилолт	2075500.00	1763400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68820640.76	62451006.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42561845.00	38905082.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360000.00	360000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3209000.00	3209000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1011400.00	905838.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	429000.00	420000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	429500.00	429500.00
210807	Газрын төлбөр	382500.00	274536.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20437395.76	17947050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	394188708.60	436396524.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6550000.00	31336954.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	302700.00	271100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	387336008.60	404788469.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7587338.00	112489432.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7587338.00	112489432.00
213303	Төлөрүүлэх шилжүүлэг	7587338.00	112489432.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	90790684.58	1450225685.57
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11893370.04	20430.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	11893370.04	20430.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-11893370.04	-20430.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	78897314.54	1450205255.57



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1231606597.00	1632092700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5769497.00	29399500.00
120	Нийтлэг татварын бус орлого	5769497.00	29399500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4688000.00	3124500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	88000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4600000.00	3124500.00
120005	Түрээсийн орлого	923997.00	0.00
120009	Бусад орлого	157500.00	26275000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1225837100.00	1602693200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1225837100.00	1602693200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1225837100.00	1602693200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1231606597.00	1632092700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1231606597.00	1632092700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1223909759.00	1493328268.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	865162062.00	1058432469.00
210101	Үндсэн цалин	664222995.00	559801964.00
210102	Нэмэгдэл	85000000.00	354268800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41877000.00	41877000.00
210104	Урамшуулал	74062067.00	102484705.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125637100.00	124843918.00
210201	Тэтгэврийн даатгал	98168400.00	81957318.00
210202	Тэтгэмжийн даатгал	6867200.00	10721700.00
210203	УОМШӨ-ний даатгал	5493700.00	8577300.00
210204	Ажигшүүдлийн даатгал	1373400.00	2144300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13734400.00	21443300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77381722.00	66457204.00
210301	Гэрэл, цахилгаан	34921227.00	30246106.00
210302	Түлш, халаалт	39461900.00	34828868.00
210303	Цэвэр, бохир ус	2998595.00	1382230.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37208315.00	73447812.00
210401	Бичиг хэрэг	2720000.00	3434300.00
210402	Тээвэр, шатахуун	29938900.00	57475860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1024915.00	1008552.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	724500.00	648100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2800000.00	10881000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59700000.00	119453409.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12900000.00	10819542.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1000000.00	5894540.00
210604	Урсгал засвар	45800000.00	102739327.00
2107	Томилголт, зочны зардал	2075500.00	1763400.00
210702	Дотоод албан томилолт	2075500.00	1763400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56442360.00	48658956.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47620960.00	40375082.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360000.00	360000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3209000.00	3209000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1011400.00	905838.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	429000.00	420000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	429500.00	429500.00
210807	Газрын төлбөр	382500.00	274536.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	300000.00	2685000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	302700.00	271100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	302700.00	271100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7696838.00	138764432.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	26275000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		26275000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	109500.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	109500.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7587338.00	112489432.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7587338.00	112489432.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	0.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	82268457.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	82268457.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	82268457.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		82268457.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-82268457.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	-82268457.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,742,699,468.58	625,729,411.50	4,875,007,883.65		9,243,436,763.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,742,699,468.58	625,729,411.50	4,875,007,883.65	0.00	9,243,436,763.73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00		0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00		0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
C07	Тайлант үеийн үр дүн			78,897,314.54		78,897,314.54
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,742,699,468.58	625,729,411.50	4,953,905,198.19	0.00	9,322,334,078.27
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,742,699,468.58	625,729,411.50	4,953,905,198.19	0.00	9,322,334,078.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,742,699,468.58	625,729,411.50	4,953,905,198.19	0.00	9,322,334,078.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бэлмэлт	0.00	0.00	0.00		0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			1,450,205,255.57		1,450,205,255.57
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,742,699,468.58	625,729,411.50	6,404,110,453.76	0.00	10,772,539,333.84



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1605693200.00	1493328268.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1605693200.00	1493328268.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1605693200.00	1493328268.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1147167000.00	1058432469.00
210101	Үндсэн цалин	646021200.00	559801964.00
210102	Нэмэгдэл	354268800.00	354268800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41877000.00	41877000.00
210104	Урамшуулал	105000000.00	102484705.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147492500.00	124843918.00
210201	Тэтгэврийн даатгал	104605900.00	81957318.00
210202	Тэтгэмжийн даатгал	10721700.00	10721700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8577300.00	8577300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2144300.00	2144300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21443300.00	21443300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66468600.00	66457204.00
210301	Гэрэл, цахилгаан	26999000.00	30246106.00
210302	Түлш, халаалт	36469600.00	34828868.00
210303	Цэвэр, бохир ус	3000000.00	1382230.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	73889900.00	73447812.00
210401	Бичиг хэрэг	3434300.00	3434300.00
210402	Тээвэр, шатахуун	57480000.00	57475860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1446500.00	1008552.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	648100.00	648100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10881000.00	10881000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	119456300.00	119453409.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10821400.00	10819542.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5894900.00	5894540.00
210604	Урсгал засвар	102740000.00	102739327.00
2107	Томилолт, зочны зардал	1784600.00	1763400.00
210702	Дотоод албан томилолт	1784600.00	1763400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49163200.00	48658956.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40656800.00	40375082.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360000.00	360000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3209000.00	3209000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1011400.00	905838.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	429000.00	420000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	429500.00	429500.00
210807	Газрын төлбөр	382500.00	274536.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2685000.00	2685000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	271100.00	271100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	271100.00	271100.00
	ЗАРДЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1605693200.00	1605817700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1602693200.00	1602693200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1602693200.00	1602693200.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3000000.00	3124500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3000000.00	3124500.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00



2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	26275000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	26275000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	26275000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26275000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26275000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00



3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Гаалийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Гэрэлт-Од танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 17-ноос 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Ухаанбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Гаалийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/14 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Гаалийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Гаалийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих;
- Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих;
- Гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих;
- Гаалийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах;
- Гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл гаргах;
- Гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах;
- Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх;
- Гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Гаалийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Гаалийн газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.



Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гаалийн ерөнхий газрын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2020 онд Гаалийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Гаалийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт хийгдээгүй байна.

Гаалийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Гаалийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 1619.2 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 32,383.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын 1994.4 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 39,889.2 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гаалийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,450.7 мянган төгрөгөөр буюу 15.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан биет бус хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	-
Авлага	851.5	1865.6	1,014.10
Урьдчилгаа	0	0	-
Бараа материал	97,491.50	74,917.50	(22,574.00)
Үндсэн хөрөнгө	9,224,455.70	10,696,790.30	1,472,334.60
Хуримтлагдсан элэгдэл	3,309,720.00	3,390,721.70	81,001.70
Нийт хөрөнгө	9,322,798.70	10,773,573.50	1,450,774.80
Өр төлбөр	464.6	1034.1	569.50
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,322,334.00	10,772,539.30	1,450,205.30
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,322,798.70	10,773,573.50	1,450,774.80

Авлагын дансны үлдэгдэл 1865.6 мянган төгрөг болж 1014.1 мянган төгрөгөөр өссөн нь ХБИ-ээс суутгасан ХХОАТ-ын дүнгээр өссөн байна.



Бараа материалын дансны үлдэгдэл 74,917.50 мянган төгрөг болж 22,571.0 мянган төгрөгөөр буурсан нь акталсан материалын дүнгээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,696,790.3 мянган төгрөг болж 1,472,334.6 мянган төгрөгөөр өссөн нь Гаалийн ерөнхий газраас шилжүүлэн авсан хөрөнгөтэй холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл нь 1,034.1 мянган төгрөг болж 569.5 мянган төгрөгөөр өссөн нь ХБИ-ээс ХХОАТ суутгасантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,773,573.5 мянган төгрөг болж 1,450,205.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд нэмэгдсэн хөрөнгийн дүнгээр өссөн байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,734,712.3 мянган төгрөгөөр буюу 101.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 1,351,029.0 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 375,277.3 мянган төгрөгөөр буюу 23.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал шилжүүлгийн зардал байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,602,693.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,602,693.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,602,693.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэх 1,602,693.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,602,693.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,493,328.2 мянган төгрөгийг зарцуулж 112,489.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,493,328.2 мянган төгрөг буюу 93.0 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд авто машины дуудлага худалдааны орлого 26,275.0 мянган төгрөг төвлөрснийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт төвлөрүүлсэн байна.



3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих нийт 149 мэдээллээс хөрөнгө актлуулсан шийдвэрийг цахим хуудсанд мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 54.1 сая төгрөгийн зөрчилд зөрчилд 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	900.0	1	900.0	-	-	-
Албан шаардлага	1	51,900.0	1	51,900.0			
Төлбөрийн акт	1	1,300.0	1	1,300.0			
Нийт дүн	3	54,100.0	3	54,100.0			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 263,397.7 мянган төгрөгийн зөрчил, 33,375.6 мянган төгрөгийн алдааг илрүүлж 4 албан шаардлага, 1 зөвлөмж, 2 аудитын залруулга хийлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 263,397.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 263,397.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлэв. Үүнд:

1. Тайлант оны нийт худалдан авалтыг татварын цахим е-баримт системийн бүртгэлээр тулгахад 31,936.7 мянган төгрөгийн худалдан авалтаар буюу 12.4 хувь нь бүртгэлгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 “Анхан шатны баримтад Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.”, Сангийн Сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан заавар, маягтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд шилэн дансны цахим сайтад төсвийн гүйцэтгэлийн мэдээнд нийт 229,576.9 мянган төгрөгийн төсөв зарцуулсан болон хөрөнгө акталсан шийдвэрийг оруулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “... өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.



3. Хөгжлийн бэрхшээлтэй, групптэй 4 ажилтны цалингаас 1015.6 мянган төгрөгийн ХХОАТ суутган авсан байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн “22.1.2 хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого;”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн “18.1.1 хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байр бий болгохыг урамшуулах;” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Он дамжсан авлага, өглөгийн 868.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар жолоочийн замын тооцооны хуудсыг түүвэрлэн үзэхэд Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалтаар батлагдсан маягтын дагуу хөтөлж ажиллах зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Нэмэлт санхүүжилтийг анхааралдаа авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Анхан шатны баримт хөтлөлттэй холбоотой

- 1.1. Илрүүлэлт: Аудитаар шалгагдагч байгууллага нь жолоочийн замын тооцооны хуудсыг бөглөхдөө Сангийн Сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан зааврын дагуу бөглөж хөтлөхгүй байна.
- 1.2. Эрсдэл: Авто машиныг хэн ашиглаад байгаа нь тодорхойгүй
- 1.3. Өгсөн зөвлөмж: Сангийн Сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг мөрдөж ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Мөрдөж ажиллана.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021	Аудитын нэр:	Гаалийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДОА-2021/105/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Гаалийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Гаалийн газар		Мянган төгрөгөөр



№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны цахим сайтад төсөв зарцуулсан, хөрөнгө актлуулсан шийдвэр дутуу байршуулсан.	229,576.9	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Гэрэлт-Од, Б.Энхбаяр
2	Он дамжсан авлага, өглөгийн үлдэгдэлтэй ажилласан	868.5	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Гэрэлт-Од, Б.Энхбаяр
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс ХХОАТ суутгаж ажилласан	1,015.6	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Гэрэлт-Од, Б.Энхбаяр
4	Е баримт цахим сайтад нийт худалдан авалтын 12.4 хувийг бүртгүүлээгүй.	31,936.7	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Гэрэлт-Од, Б.Энхбаяр
5	СС-ын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягт нөхөх зааврыг мөрдөж ажиллахгүй байна.	0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Гэрэлт-Од, Б.Энхбаяр
ДҮН		263,397.7			